



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/30

Дадал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь заалт, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.8 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарыг нэмэгдүүлэх, сурагчдын математик сэтгэлгээг хөгжүүлэх, эх хэлний мэдлэгийг сайжруулах, багшийн хөгжлийг дэмжих зорилгоор Улсын тэргүүний Дадал сумын Засаг даргын нэрэмжит 1-12 дугаар ангийн сурагчдын дунд монгол хэл, математикийн хичээлийн массын олимпиадыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:	Д.Гэрэлмаа	(Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд:	М.Эрдэнэбулган	(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
	Б.Мөнхзул	(Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан)
	Б.Эрдэнэцэцэг	(ЕБС-ийн сургалтын менежер)
	Ч.Ганчимэг	(ЕБС-ийн сургалтын менежер)
	О.Бүжмаа	(Монгол хэл, уран зохиолын багш)
	Ө.Хэрлэнбаяр	(Математикийн багш)

2.Улсын тэргүүний Дадал сумын Засаг даргын нэрэмжит 1-12 дугаар ангийн сурагчдын дунд монгол хэл, математикийн хичээлийн массын олимпиадыг чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000179